

СУДЛААЧ, ОРЧУУЛАГЧ ШӨГӨӨ ОВОГТ ОЙДОВЫН АДЪЯАГИЙН НАМТАР, ТУУРВИЛ, ОРЧУУЛГЫН ОНЦЛОГ

А.Сүхмаа¹⁴⁵

Товч утга: Профессор Ойдовын Адъяа нь Монголд зэрэгцүүлсэн хэлишинжлэл, орчуулга судлалыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж буй судлаачдын тоонд зүй ёсоор тооцогддог бөгөөд тэр дундаа нэр томьёо судлалын чиглэлээр голлон судалгаа хийн үүнийхээ талаар нэг сэдэвт зохиол туурвиж мөн олон тооны илтгэл, өгүүлэл хэвлүүлжээ. Энэхүү ажилдаа түүний товч намтар болон бүтээл туурвилыг нь олон түмэнд танилцуулахын зэрэгцээ, орчуулгын онцлогийг цухас дурдахыг зорьлоо. Чингэснээрээ орчуулгад шамдан орж буй залуу судлаачдад бага ч атугай тус дэм болж цаашдын ажилд нь тусгалаа олох байх хэмээн найдаж байна.

Түлхүүр үг: хэлишинжлэл, орчуулга, үг сонголт, найруулга, орчуулгын анализ

Товч намтар

Ойдовын Адъяа нь Өвөрхангай аймгийн Өлзийт сумын нутаг “Их булагийн Улаан булаг” гэдэг газар 1950 онд төржээ. 1958 онд Өлзийт сумын бага сургуульд элсэн орж 1968 онд Хужирт сумын арван жилийн сургуулийг төгсөж, улмаар УБДС-ийн Орос хэлний факультетэд элсэн суралцаад 1973 онд орос хэл, уран зохиолын багшийн мэргэжлээр төгссөн байна.

1985-1987 онд Москва хотод А.С.Пушкиний нэрэмжит Орос хэлний институтийн аспирантурт суралцаж, “Нийгэм-улс төрийн эх бичвэрийн нэр нийлэмжийн бүтэц-утгазүйн хэв шинж” сэдвээр хэлбичгийн ухааны дэд эрдэмтний, 2000 онд Улаанбаатар хотноо “Орос, монгол нэртомьёоны бүтэц-утгазүйн харьцуулсан судалгаа” сэдвээр хэлбичгийн шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан.

1973-1997 онд ХААДС, Намын дээд сургууль, Улс төрийн дээд сургууль, Төр, нийгэм судлалын Академи, МУИС-ийн орос хэл, гадаад хэлний тэнхимд багш, тэнхмийн эрхлэгчээр, 1997-2000 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар тус тус ажиллаж байгаад, 2000 оноос ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн даргын албыг тус тус хашиж байв.

“Учебник русского языка /элементарный курс/” /УБ., 1982/, “Русский язык /учебник русского языка для слушателей ВПШ при ЦК МНРП/ /УБ., 1985/”, “Словарь-справочник по именной сочетаемости русского и монгольского языков” /УБ., 1982/, “Учебное пособие по русскому языку для студентов

¹⁴⁵ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш, докторант

филологического профиля” /УБ., 1996/, “Ухаант ардын үнэт өв. Английн мянган зүйр, цэцэн, хэлц үг /орос, монгол орчуулга болон дүйцтэй/. Ертөнцийн гурав, дөрөв /орос, англи орчуулгатай/”, /УБ., /1996, УБ. 2007/, “Пособие по переводу с монгольского языка на русский” /УБ., 1983/, “Учебное пособие по русскому языку /традиции и обычаи монголов/” /УБ., 1997/, “Бямбын Ринчен” /УБ., 2003/, “Хэл, хэлшинжилэл, орчуулга: сурахуй, сургахуй, судлахуй” /УБ., 2005/ зэрэг хамтын хийгээд бие даасан арав гаруй ном бүтээл туурвижээ.

Үүний зэрэгцээ судалгааны дөч шахам өгүүлэл бичиж нийтүүлсэн нь монгол, орос, англи хэлээр эрдэм шинжилгээний эргэлтэд орсон бөгөөд дотоодын болон олон улсын хуралд гуч шахам илтгэл хэлэлцүүлсэн байна.

1995 онд Монгол Улсын ЭЗЦОДЗ-өөс дэд профессор, 2002 онд УБИС-ийн эрдмийн зөвлөлөөс профессор цолыг тус тус олгожээ.

Зэрэгцүүлсэн хэлшинжлэл, нэр томъёо судлалаар доктор /PhD/-ын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн, Хэлбичгийн шинжлэх ухааны доктор /Sc.D/-ын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн гишүүнээр тус тус томилогдон ажиллаж байна.

Түүний орчуулгын зарим бүтээлд анализ хийсэн тухайд

Тэрээр Чингиз Айтматовын “Анхны багш” (1965) туужийн орчуулгад (Л.Чойжилсүрэн) хоёр төрлийн алдаа байна гэсэн.

Нэгдүгээрт: “Орос хэлний хэлзүйн дүрмийн мэдлэг дутмагаас болж эх зохиолд гарч байгаа санааг буруу илэрхийлсэн байна.” (О.Адъяа, 2005:179). Жишээ нь: “Дюйшен приостановил лошадь и первый раз посмотрел на меня **измученными глазами**”(с.352) гэсэн өгүүлбэрийг “Дюйшен багш сая морио зогсоон, миний зовж шаналсан нүд рүү анх удаа харлаа” (х.226) гэж *Дюйшен багшийн зовж шаналсан нүдийг өөр хүнийх болгожээ* гэсэн байна.

Хоёрдугаарт: “Хэдийгээр хэлзүйн дүрмийн хувьд зөв боловч хэл найруулга нь болхи тул монгол хүний чихэнд чийр болмоор хэллэг таарч байна” (О.Адъяа, 2005:180). Жишээ нь: “Раненная рука его висела на повязке...” (с.332) гэснийг “Тэрвээр шархтай гараа хүзүүнээсээ оосорлон уясан агаад...” (х.193) гэх орчуулгыг *саланги тусдаа юмыг хаячихвий гэж л хүзүүнээсээ оосорлон уяж болох юм, харин бэртсэн гарыг бол монголчууд сойдог байх* гэжээ.

А.С.Пушкиний зарим зохиолд хийсэн түүний анализаас харахад нийтлэг гаргаж буй хоёр алдаа байна гэж үзсэн байна.

Нэгдүгээрт: “Эх зохиолын утга санааг зөв ойлгосон атлаа хэл найруулгын хувьд орос эхдээ баригдан монгол биш гэмээр өгүүлбэрүүдийг

бүтээжээ.” (О.Адъяа, 2005:182). Жишээ нь: Д.Нацагдоржийн орчуулсан “Буудалцсан нь” өүүллэгт: Впрочем, нам **в голову не приходило подозревать** в нём что-нибудь похоже на робость (с.250) – Түүнийг аймтгай мөхдөг гэмээр ямар нэг **сэжиглэл манай сэтгэлд төрсөнгүй**. (х.14) гэснийг О.Адъяа “Гэвч түүнийг аймхай хулчгар гэмээр ямар нэг сэжиг бидний сэтгэлд төрсөнгүй.” хэмээн орчуулсан байна.

Хоёрдугаарт: “Эх зохиолын утга санааг буруу ойлгосноос гол төлөв олон утгатай үгийн тухайн хам сэдэвт тохирох утгы нь олж чадаагүйгээс үүдэн гарсан алдаа байна.” (О.Адъяа, 2005:183). Жишээ нь: Э.Оюуны орчуулсан “Шуурга” гэдэг туужид: ...**две недели находилась у края гроба**. (с.266) – **хоёр долоо хоногийн дотор үхэх сэхэх нь мэдэгдэхгүй** хэвтэв. (х.33) гэсэн орчуулгыг тэрээр **хоёр долоо хоног үхлүүд хэвтэв** хэмээн орчуулж байна.

Resume

As a conclusion, every language becomes a tool to express any nation’s lifestyle, customs and culture, thus a person who is studying any language needs to study its customs and culture as well. As a consequence, the translation can be better and more understandable to the readers. According to the examples mentioned above, the translations are not good enough as the translator does not know its grammar well and also word choice is so bad that the reader cannot understand the text completely. So, translators should have good grammatical knowledge and be familiar with the word choice and its usage. They also ought to be skillful enough to translate the text in an interesting and comprehensive way especially in literature by using pleasant words and expressions which can attract the readers’ attentions.

О.Адьяагийн бүтээлээс

Нэг сэдэвт зохиол

1. Структурно-семантическое типы русских именных (субстантивных) словосочетаний в общественно-политических текстах. –М., 1986.-189с.
2. Сопоставительное структурно-семантическое описание русской и монгольской терминологий (по материалам последних 7-8 десятилетий XX в.) –УБ:, 2000.-240 с.

Хамтарсан бүтээл

1. Словарь-справочник по именной сочетаемости русского и монгольского языков (В соавторстве с Э. Равдан). Под ред.доц. Д.Дашдавы. –МНР: Изд-во ГКВСС и ПТО, УБ, 1982.-264 с.
2. Бямбын Ринчен (Ц. Шагдарсүрэнгийн хамт) “Монгол Улсын шинжлэх ухаан” (108 боть) цувралын 5 дахь боть (УБ., 2003, 288х.)
3. Идээний дээж: эрт эдүгээ. (Г.Даштүдэв, Х. Сампилдэндэв нарын хамт), УБ., 2006. -110 х.
4. Идээний дээж: судар шастир хийгээд аман зохиолд. (Э.Пүрэвжав, Х. Сампилдэндэв нарын хамт), УБ., 2007. -230 х.

Сурах бичиг

1. Учебник русского языка (Элементарный курс) (В соавторстве с Д.Дашдаваа, В.С. Ключевым, Л.П. Семёновой). Под ред. доц. Д.Дашдавы-МНР: Госиздат, УБ, 1982-304 с.
2. Русский язык (Учебник русского языка для слушателей ВПШ при ЦК МНРП) (В соавторстве с Д.Дашдаваа, З.Дашдорж, В.И. Изосимовой, К.Б. Руновой, Ш.Сүхээ, Ц.Чогдон) –МНР, Госиздат, УБ, 1985. -272 с.

Гарын авлага

1. Книга для чтение. Пособие для студентов-инженеров сельского хозяйства, УБ., 1978. -164 х.
2. Пособие по практической грамматике русского языка (В соавторстве с В.С. Ключевым и Л.П. Семёновой). Выпуск I, УБ., 1980. -60 с.
3. Пособие по практической грамматике русского языка (В соавторстве с В.С. Ключевым и Л.П. Семёновой). Выпуск II, УБ., 1980. -68 с.
4. Пособие по переводу с монгольского языка на русский (В соавторстве Д.Дашдаваа и П.Увш). Под ред. Б.Чулуундоржа – МНР. Госиздат, УБ., - 1983. -128 с.
5. Учебное пособие по русскому языку для студентов филологического профиля. Под ред. доц. Д. Цэенрэгзэна. –УБ, 1996. -86 с.

6. Учебное пособие по русскому языку (традиции и обычаи монголов) (В соавторстве с П.Увш). Под ред. доц. О.Адьи. –УБ, 1997. -154 с.

Ном

1. Ухаант ардын үнэт өв. Английн мянган зүйр цэцэн, хэлц үг (орос, монгол орчуулга болон дүйцтэй). Ертөнцийн гурав, дөрөв (орос, англи орчуулгатай). Хянан тохиолдуулсан Н.Доржготов. (1 дэх хэвлэл –УБ, 1996. -174 с.; 2 дахь хэвлэл –УБ., 2007. -237 х.)
2. Хэл, хэлшинжлэл, орчуулга: сурахуй, сургахуй, судлахуй: Тэргүүн дэвтэр, УБ., 2005, -223 х.
3. Орчуулга: онол, туршлага, сургамж. Дэд дэвтэр, УБ., 2008. -182 х.

Эрдэм шинжилгээний төсөл, судалгаа

Удирдсан суурь судалгааны сэдэвт ажил

1. “Хэрэглээний хэлшинжлэлийн онол, практикийн судалгаа” сэдэвт ажлын удирдагч, 2005-2007
2. “Орос-монгол дэлгэрэнгүй их толь ба нэртомьёо судлал” сэдэвт ажлын удирдагч, 2008-2010

Оролцсон суурь судалгааны сэдэвт ажил

1. “Монгол хэлний толь зүй, нэртомьёоны судлал”, 1997-2000
2. “Монгол хэлний толь зүй, нэртомьёоны судлал”, 2001-2004
3. “Нүүдэл, иргэншил: өнөө, ирээдүй”, 2006-2008
4. “Даяаршлын эринд үндэсний монгол судлалыг хөгжүүлэх тулгамдсан асуудал” 2008-2010